

ЛИБЕРАЛ БОЛОВСРОЛ (ЛБ) ГЭЖ ЮУ ВЭ ? (ҮҮСЭЛ, ТОДОРХОЙЛОЛТ, ЗОРИЛГО, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, СУРАХ , СУРГАХ ҮЙЛ, БҮТЦИЙН ОНЦЛОГ)¹

Э. РАВДАН (МУИС)

1. *Өмнөтгөл.* Постсоциализмын улс орнуудад АНУ-ын их, дээд сургуулийн холбооноос санал болгосон ЛБ-ын тогтолцоог өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Төв, Баруун болон Өмнөд Европ, Ази, Африкийн олон улс орны багш нар дээд боловсрол олгох загвар болгон хүлээн авсан байна². Өдгөө эл хөдөлгөөн дэлхийн олон улс оронд тархаж цөөнгүй улс орон эл тогтолцоонд шилжихээр анхны алхмаа хийгээд байна. Түүний дотор, ялангуяа коммунизмын үзэл баримтлал унасан хуучин ЗХУ-ын орон зайн улс орнууд болон хөгжлийн социалист чиг хандлагатай байсан орнууд, түүний дотор Монгол улсад ч гэсэн ЛБ-ын тогтолцоог их, дээд сургуулийн хуучин хатуу, уян хатан биш тогтолцоог халж оронд нь төлөвшүүлэхээр “шүүрэн” авлаа. Тийнхүү үзэхийн ул суурь нь ЛБ нь тухайн улс орнуудад нийгмийн амьдралд гүйцэтгэх иргэдийн үүрэг идэвхжиж улс төр, нийгмийн чиг хандлага, хэтийн зорилгод нь таацаж байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, дээрх улс орнуудад ЛБ-ыг нийгмийн амьдралыг ардчилах үйлийн суурь дэвсгэр, иргэн хүнд нийгмийн идэвхтэй байр суурь олгох гол арга зам хэмээн хүлээн авч байна. Тэгвэл дэлхийн бусад бүс нутгийн улс орнуудад орчин үеийн шинжлэх ухаан технологийн хөгжлийн хурд, өрсөлдөөнтэй холбон их, дээд сургуулийн профессор багш нар сургалтын хуучин аргын хязгаарлагдмал талыг илүүтэй ухаарч оюутан залуучуудыг хүчээр сургах гэсэн хандлага нь өнөөдрийн зах зээлийн сэтгэлгээтэй зөрчилдөх болсныг мэдрэх болжээ.

Гэхдээ ЛБ-ын дээрх үйл явц тийм ч амархан биш болох нь эхнээсээ мэдэгдсэн байна³. Хамгийн гол нь өөрчлөлтийг санаачлагчид нь ЛБ-оо цааш хэрхэн хөгжүүлэхээ мэдэхгүй мухардалд орж байсан нь цөөнгүй байв. Европын нэлээн олон оронд холын АНУ-гаас урьж ирсэн шинжээчид нь тухайн улс орны өвөрмөц онцлог, нөхцөл зэргийг

¹ Зохиогч энэхүү өгүүлэлдээ дэлхийн олон улс орон, тэр дундаа Монгол улсын зарим их, дээд сургуульд хэрэгжиж эхлээд байгаа ЛБ-ыг боловсролын тогтоолцоог салбарын удирдах төрийн байгууллага, их, дээд сургуулийн удирдлага, суралцагч оюутан залуучууд, түүний ард байгаа олон түмэнд чухам ямар тогтолцоо, түүний сайн тал, хэрэгжүүлэхэд гарах бэрхшээл, хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл, шаардлага зэргийн талаар нэг талын туйлшралд хөтлөгдөлгүй таниулах, тэгснээр уг тогтолцоог бүх нийтээр шүүн хэлэлцэх боломжийг хангах зорилго тавьсан болно. ЛБ-ыг хий хоосон магтан дуулах эсвэл эсрэгээр хараар будахгүйн тул уг өгүүлийг Барууны болон Азийн их, дээд сургуулиудад ажиллаж байгаа гол төлөв АНУ-ын ЛБ-ын шинжээчдийн дүгнэлтээс ашиглан бүтээсэн болно. Өгүүлэл тийнхүү нийтэд хандсан учир зохиогч нарийн нэр томъёо, ойлголт ухагдуунаас аль болохоор зайлсхийсэн болно.

² Gillespie S. *Opening minds: The International Liberal Education Movement*. World Policy Journal, Winter 2001 / 2002 p. 79-89

³ Анх ЛБ-ыг санаачилсан АНУ-ын зарим судлаач өдгөө ЛБ-ыг “хуучирч, үеэ өнгөрөөсөн”, “өөрчлөн шинэчлэх шаардлагатай, нийгмийн цөөнхийн” боловсрол гэх мэтээр шүүмжлээд эхэлжээ. Үүнийг дараах илтгэл, өгүүллээс үзнэ үү. Үүнд: Corner W.R. *Liberal Arts Education in the Twenty-First Century* AALE Occasional Paper, May 1998 www.aale.org/conner.htm, Barker C.M. *Liberal Arts Education for Global Society*, Carnegie Corporation of New York, 2002, p. 9. Katz S. *Restructuring for the Twenty-First Century* N.H. Farnham, A. Yarmolinsky (eds.) *Rethinking Liberal Education*. New York: Oxford University Press, 1996, p.77-90. Гэвч сүүлийн үеийн нөхцөл байдлаас харвал “галт тэрэг нэгэнт хөдөлчихсөн” бололтой.

мэдэхгүй, зөвхөн ЛБ-ын ирээдүйд биелэх гайхамшигт үр дүнгийн талаар мөрөөдөхөөс хэтрэхгүй байх зэрэг нь ажиглагдаж байна.

2. *ЛБ-ын үүсэл, хөгжил.* ЛБ-ыг түүхэн урт хугацаанд маш өргөн, ерөнхий, заримдаа өөр хоорондоо сөргөлдсөн агуулгаар⁴ тодорхойлж иржээ. Axelrod, Anisef, Lin нар ЛБ-г, тухайлбал эртний Грегийн боловсрол олгох уламжлалаас үүдэн тодорхойлж байжээ. Тэр үеийн нийгмийн нийт хүн амыг зарц, чөлөөт иргэн гэж хувааж чөлөөт иргэд нь нийгэмд гүйцэтгэх эрх, үүргийнхээ хүрээнд тусгай, мэргэжлийн бус боловсролтой байх учиртай байв. Эл суурин дээр чөлөөт урлагийн боловсрол олох тухай асуудал анх тавигдсан ажээ. Мөн тэр үед Сократ болон түүний үзэл бодлыг дэмжигчид хувь хүний боловсролыг чухалчлан өөрийн сурагчдыг бясалгалын гэхээсээ илүү учир шалтгааны үүднээс санаа бодлоо илэрхийлж сургах талд их анхаарч байжээ. Эртний Афины боловсролд хувь хүний бие, сэтгэлийн хөгжлийн тэнцлийг хангахыг эрхэмд үздэг байв. Тэгвэл Дорнын улс орнуудад, тухайлбал Хятадын Жоу гүрний үед Күнзийн сургаалыг хувийн өмч, ёс суртахуун, нийгмийн хэв журмын үүднээс номлодог байжээ⁵.

Гэхдээ Дундад зууны “бүдүүлгүүдийн” эхэн үед ЛБ-ын асуудал өөрийн эрхгүй унтарсан ч Аристотелийн гүн ухааны сэтгэлгээ сэргэсэн XI-XII зууны үед уг асуудалд дахин хандах болов. XIII-XIV зуунд Европын улс орнуудад шашны өрөөсгөл боловсролын эсрэг хандлага үүсэж, Бурхан гэхээсээ илүү “Хүн” ойлголтыг анхаарлын төвд тавьж эхэлсэн байна. Тийнхүү, эл хүмүүнлэгийн хандлага нь учир шалтгаан, байгаль, гоо зүйн олон ойлголтоор улам бүр баяжжээ.

Өмнөх үеийн оюуны сонгодог уламжлал, хүмүүнлэгийн хандлага нь XIV зуунд Эртний Грег, Латины соёлоос суралцах үйлд аажмаар шилжсэн байна. XV-XVI зуунд ЛБ нь гол төлөв оюуны сонгодог уламжлалд суурилж байв. Гэхдээ энгийн хүмүүс аажмаар сонгодог хэл-соёлд сурахын оронд эх хэл, уран зохиол, шинжлэх ухааны бусад салбарт суралцахад илүү тэмүүлэх болов.

Барууны орнуудын ЛБ-ын тогтолцоо манай гарагийн бусад бүс нутгийн улс орнуудад ч нөлөөлжээ. Тухайлбал, Японд гэхэд Тайшогийн үед чөлөөт үзлийн хүрээнд ЛБ-д суурилсан цөөнгүй сургууль 1920 оны үед байгуулагдаж байжээ. [大正自由教育運動](#)-аас үзнэ үү.

ЛБ, мэргэжлийн боловсрол хоёр нь өөр хоорондоо ялгаатай. Германы их сургуулиуд XVIII зуунаас мэргэжлийн боловсролын чигийг барьж эхэлсэн бол АНУ-ын тогтолцоо нь ЛБ-ыг илүүтэй эрхэмлэсээр иржээ. Тиймээс АНУ-ын их, дээд сургуулийн оюутнууд сургалтын эхний эсвэл бүр хоёр дахь жилээсээ мэргэжлийн боловсролд шилжин ордог байна⁶. АНУ-ын либерал урлагийн коллежууд бүр XX зууны эхэн үеэс сургалтын ерөнхий хөтөлбөрөөр хичээллэж эхэлсэн бол нийтийн (public) их сургуулиуд нь сургалтын эхний хоёр жил ерөнхий суурь боловсролын хичээл үзсэнийхээ дараа мэргэжлийн хичээлүүдээ үзэж эхэлдэг ажээ. XX зууны дунд үеэс

⁴ Van Doren, Mark (1943) *Liberal Education*. New York: Hanry Holt and Company-ээс энэ тухай үзнэ үү.

⁵ Xin Chen (2004) *Social Changes and the Revival of Liberal Education in China since 1990s* Asia Pacific Education Review 5 (1) p.1-13

⁶ Kiener, R. (2013 January 18) *Future of public universities*. CQ Researcher, 238 52-80 Retrieved from <http://libery.cqpress.com/cqresearcher/> -ээс үзнэ үү.

АНУ-д мэргэжлийн боловсролд тавих анхаарал нэмэгдэж коллежууд нь дээрх хоёр сургалтын харьцааг шинээр авч үзэх болсон байна.

Чикагогийн их сургуулийн профессор Martha Nussbaum-ын тэмдэглэснээр стандарт сорилгын тогтолцоо нь ангиар олгох мэргэжлийн мэдлэгийг тогтооход илүү чиглэгдэх бөгөөд түүний хариултын тоо болон олноос сонгох мөн чанар нь анги дахь сургалтын үеэр мэдээллийг хоосон цээжлэх үйлд суралцагчдыг түлхэж байна. Тэгвэл суралцагчдын төсөөлөн бодох, мэдээлэлд шүүмжлэлтэйгээр хандах сэтгэлгээнд сургах үйлийг дээрх аргаар үнэлж дүгнэх боломжгүй гэж үзжээ⁷.

АНУ-д коллеж төгсөгчдийн 30 хувь нь (доор эшилсэн Fong, Bobby (Winter 2004) бүтээлээс үзнэ үү.) өмнө нь байгаагүй шинэ ажил мэргэжил эрхэлж байна. ЛБ-ын сайн тал нь ерөнхий боловсролын сургуулийн дараа оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд зохицуулсан суурь мэдлэг олгоход чиглүүлдэг ажээ. Өөрөөр хэлбэл, эл тогтолцоо нь төгсөгч хүнд хөдөлмөрийн зах зээл дээр өргөн мэргэжлийн хүрээнд нэгээс нөгөө ажилд хөрвөж чадах суурь мэдлэг олгох явдлыг чухалчилдаг.

2.ЛБ-ын тодорхойлолт. ЛБ нь хүмүүний чөлөөт (латин үг: *liberalis* ‘чөлөөт’) нийгэмд тохиромжтой боловсролын нэгэн тогтолцоо мөн. Тэр нь Европын дундад эртний Гэгээрлийн үед чөлөөт урлагийн ухагдахуунд суурилсан ойлголт байв. АНУ-ын их, дээд сургуулийн холбооноос гаргасан ЛБ-ын тодорхойлолт⁸ болон бусад сурвалж баримтуудын заалт зэргийг нэгтгэн ЛБ-ыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд, *орчин цагийн ЛБ нь суралцагч хүнд сурах хүсэл, сурах чадавхыг хөгжүүлж, аливааг шүүмжлэлтэй сэтгэн бодох, өөрийн санаа бодлоо чадамгай илэрхийлж сургаахаас гадна түүнийг ардчилсан нийгмийн идэвхтэй оролцогч болгон хүмүүжүүлэх зорилгыг хангах дээд боловсролын тогтолцоо мөн* болно. Сургалтын эл тогтолцоо нь үзэж байгаа хичээлээ суралцагч хүн аль болохоор өргөн хүрээтэй, гүн гүнзгий мэдэх, үзэх хичээлээ эхнээсээ чөлөөтэй сонгох хоёр боломж нөхцөлөөр хангасан сургалтын хувийн төлөвлөгөөнд суурилахын зэрэгцээ ангид болон ангийн гадуур задлан шинжлэх бичвэрийн ажилд оюутныг татан оруулж, багш нарын зүгээс оюутанд хандсан харилцан ярилцах идэвхтэй аргыг хослуулснаараа сургалтын ижил төстэй бусад тогтолцооноос өвөрмөц ялгаатай. “Тогтолцоо” гэх ойлголт нь юуны өмнө сургалтын бүхий л үйлийг тодорхойлсон цогц бөгөөд тэр нь сургалтын зорилго, төлөвлөгөө, багшлах аргагүй, захиргааны бүтэц зэргийг өөртөө багтаадаг. Түүнээс гадна уг тогтолцоотой холбоотой багш, оюутан, сургуулийн удирдлага сургалтын чиглэл, үр дүн, шаардлагыг сайтар ухамсарласан байна

3. ЛБ-ын зорилго. ЛБ-ыг хангагч сургалтын байгууллагын зорилго нь *суралцагчийг тодорхой үйлд бэлтгэхээсээ илүү хувь хүний хувьд хөгжүүлэхийг* гол болгодог байна. Хэрэв бид ЛБ-ын эх сурвалж-эртний Герегийн уламжлалд хандвал: ЛБ-ын зорилго нь ардчилсан нийгмийн идэвхтэй оролцогч болох чадавх бүхий хүнийг хүмүүжүүлэх явдал байв. Тэгвэл одоо өмнөх үеэ бодвол үсрэнгүй хөгжил бүхий өнөөгийн нийгмийн орчинд оюутан залуучуудад зах зээлийн орчинд зохицсон олон

⁷ Nussbaum, Martha C. (Summer 2009) *Education for Profit, Education for Freedom*. Liberal Education (Association of American Colleges and Universities) 95 (3) p.6-13

⁸ Fong, Bobby (Winter 2004). *Looking Forward: Liberal Education in the 21st Century*. Liberal Education (Association of American Colleges and Universities) 90 (1) p.8-13

талын үйлийн үндэс суурийг бэлдэх зорилго тавьж байна. ЛБ-ын талыг баримтлагч хүн хичээл сургуульдаа дуртай, аливаад шүүмжлэлтэй хандаж, өөрийгөө илэрхийлж сурах чадавх нь нэг хичээл буюу нэг мэргэжлийн гүн бат мэдлэгээс хавьгүй чухал үүрэгтэй гэдэгт гүн гүнзгий итгэдэг. Эл чанар нь сургуулиа дүүргэсний дараа байнга өөрчлөгддөг нийгэм-эдийн засгийн зах зээлийн орчин нөхцөлд түргэн дасаж дадах, хөрвөх чадвартай болгоход тусалдаг ажээ.

4.Сургалтын төлөвлөгөө. ЛБ-ын тодорхойлох гол бүрэлдүүн хэсэг нь сургалтын төлөвлөгөө, профессор багш нарын заах аргын асуудал бөлгөө. Хожмын гайхамшигт үр дүнгийн тухай магтан өгүүлэх нь нэг хэрэг, харин тэрхүү амжилтад хүргэх арга зам, бодит нөхцөлийг бүрдүүлэх нь огт өөр хэрэг юм.

ЛБ-ын тогтолцооны хамгийн чухал хэсэг нь суралцагч хүнд *сонгох эрхийг* эдлүүлсэн сургалтын төлөвлөгөө юм. Уг төлөвлөгөө нь суралцагч хүнд их, дээд сургуульд элсэж орсныхоо дараа үзэх хичээлээ сонгох өргөн боломж олгохоор зохиогдсон байхаас гадна, мэргэжлээ буюу сонирхлын эрдэм шинжилгээнийхээ салбарыг сонгох сонголтын үндсэн хоёр хэлбэрийг хангасан байх учиртай. Өөр өнцгөөс нь харвал, *суралцагч хүн өөрөө өмнөөс зорьсон сурах төлөвлөгөө, хөтөлбөртэй байх нь сургалтын үйл явцыг ардчилах үндсэн нөхцөл нь болно.* Их, дээд сургуульд элсэгчид хичээл хийгээд мэргэжлээ сонгох эрхтэй болсон нь, нөгөөтээгүүр дээд боловсролтой нийт хүнд зориулсан сургалтын ерөнхий нэгдсэн төлөвлөгөө, нийтлэг арга зам байхыг үгүйсгэж байна. Тийнхүү суралцагч хүн өөрөө ирээдүйн мэргэжил буюу эрдэм шинжилгээнийхээ салбарыг сонгох болсноор тэр бээр нийгэмд “эзэндээ бурантаглуулсан тэмээ” биш, цааш өсөж хөгжих чадавх бүхий, ирээдүйд өөртөө тов тодорхой зорилго тавьсан хувь хүн-бодгаль болохоо нотолж байгаа хэрэг юм. Тийм чанарыг сурагч хүнд төлөвшүүлэх нь бага, дунд ерөнхий боловсрол, их, дээд сургуулийн сургуулийн томоохон зорилт болох учиртай бөлгөө. Тийм төлөвшил бүхий хүн их, дээд сургуульд элсэх ёстой болж байна.

ЛБ-ын үүднээс сургалт нь суралцагч хүнд их мэдлэг олгоно гэхээсээ илүү аливаа асуудалд шүүмжлэлтэй хандаж сурах чадавхыг хөгжүүлэх урт удаан хугацаанд үргэлжлэх үйл явц бөлгөө. Эл чанараараа ЛБ нь Европын болон Азийн олон улс оронд түгсэн их, дээд сургуулийн сонгодог тогтолцооноос зарчмын эрс ялгаатай. Уламжлалт их, дээд сургуульд элссэн суралцагчид нь, жишээлбэл түүх, хууль эсвэл инженер гэх мэт бичил их сургуулиуд буюу факультетэд ороод, түүнээсээ гарахгүйгээр 4-5 жил суралцдаг. Сургалтын энэхүү сонгодог хэлбэр нь их, дээд сургуульд элсэгч хүн мэргэжил, ирээдүйн эрдэм судлалынхаа чиглэлийг тогтоогоод ирсэн гэж үздэг учир суралцагч хүний бололцоо боломжийг хязгаарладаг байна.

Гэвч суралцагчдын сонгох эрх гээч нь “дураараа” байхын эхлэл биш. ЛБ-ын сургалтын төлөвлөгөө нь суралцагч хүнд *өргөн мэдлэг, судалгааны гүн гүнзгий чадвар олгох* шаардлага хангасан байх учиртай. *Өргөн мэдлэгийг* олгох үүднээс элсэгчдэд эхний үед судалгааны нийтлэг аргачлал, мэдлэг олох арга зам зэрэгтэй танилцуулах үүднээс ерөнхий эрдмийн сонгодог хичээлүүдийг нийтэд нь заавал заадаг байна.⁹ Сургалтын төлөвлөгөөний эл шаардлагуудыг олон сургууль байнга

⁹ АНУ-ын зарим дээд сургуульд суралцагч хүнд хэд хэдэн хичээлийн бүлгийг санал болгож тухайн бүлгийнхээ хүрээнд оюутан хичээлээ сонгох зарчим үйлчилдэг ажээ. Жишээлбэл, Сонгодог урлагийн “Бард” дээд сургуульд гэхэд оюутнууд: гүн ухаан, гоозүй, урлагийн тухай үзэл баримтлалууд; утга зохиолын бичвэрүүд ба хэл шинжлэл; нийгмийн болон түүхийн хичээлүүд; гадаад хэл, соёл; байгалийн болон нийгмийн олон ухаан ба

хянан хэлэлцэж зохих өөрчлөлтийг оруулдаг. Энд дараах гурван хүчин зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд: 1) ЛБ-ын тогтолцооны агуулгын стандартыг гүйцэлдүүлэх үүднээс тухайн сургуульд сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хянах бүтцийн нэгж заавал байна. Хэрэв оюутнууд цөөн хичээл сонгож түүгээрээ “алба” хаахыг оролдвол тэр нь уг тогтолцоог учир утгагүй болгох эрсдэлтэй. 2) ЛБ-ын орчин үеийн хувилбараар сургалтын төлөвлөгөө нь урлаг, хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарын судлалаар хязгаарлагдахгүй, байгалийн ухаан, математикийг хүртэл өөртөө багтаах ёстой байна. ЛБ нь олон хүний ойлголтоор хүмүүнлэгийн салбартай холбоотой гэж үздэг хэдий ч хэрэв суралцагч залуучууд орчин үеийн шинжлэх ухааны үзэл баримтлалуудын учрыг ухаарахад хөтлөгдөх нь их тул сургалтын төлөвлөгөөнд байгалийн ухааны салбараас хичээлүүд байхыг үгүйсгэж болохгүй. 3) Гэхдээ сургалтын төлөвлөгөөнд тавих шаардлага нь бас хэтэрхий их байвал суралцагч хүний сонгох эрх, өмнө тэмдэглэснээр эрсдэлд орох талтай.

ЛБ-ын сургалтын төлөвлөгөөний суралцагч хүнд гүн бат мэдлэг олгох тал нь оюутан багш нарынхаа оролцоотойгоор тэр бээр эрдэм шинжилгээний салбар буюу мэргэшлээ сонгон авна. Оюутанд тавих шаардлага нь энэ үед тов тодорхой байх учиртай. Сургалтын байгууллага нь оюутны сонгож авсан цогц хичээлийн нь зэрэгцээ зохистой дараалал бүхий заавал үзэх хичээлүүдийг үзэж танилцахыг шаардах эрхтэй. Түүнчлэн багш нар оюутанд салбар хоорондын завсрын чанартай хичээл үзэхийг зөвлөж болно. Тийнхүү сургалтын төлөвлөгөөнд хандахын учир нь тухайн их, дээд сургуулийг төгсөгч хүн ганц дан мэргэжлийн зөвхөн тодорхой нэг салбараар мэргэшихээс гадна хэд хэдэн салбарт цааш суралцан хөрвөх чадвартай болох үндэс суурийг тавихад чиглэсэн байна. Энд гойдлон тэмдэглэхэд, мэргэшүүлэх чиглэл нь уламжлалт шинжлэх ухааны салбараар хязгаарлагдах албагүй. ЛБ-ын тогтолцоо нь тийнхүү хичээл хоорондын хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлснээр суралцагч хүнд оюуны иж бүрэн суурь боловсрол олгоход чиглэдэг.

5. Сургах аргазүй. ЛБ-ын тогтолцоог тодорхойлох чухал нэг бүрэлдүүн хэсэг нь сургах аргазүй болой. Багш нар тухайн асуудлыг авч үзсэн судлаачдын үзэл бодолтой оюутнуудаа танилцуулж, тэднийг уг асуудалд шүүмжлэлтэй хандсан бичвэрүүдийг бие даан уншихыг шаардах замаар тэдний задлан шинжлэх арга барилд сургадаг байна. Өөрөөр хэлбэл, энд сургалтын өөр агуулга төдийгүй, бүхэлдээ боловсролын үйл явцад шинэ хандлага нь чухал юм. Оюутан баримжаатай багш, оюутны харилцан идэвхтэй ажиллах аргазүйг нэвтрүүлснээр багшаас оюутанд мэдлэг олгох нэг талт сургалтын уламжлалт үйл ажиллагаа үйлчлэхгүй болно. Их, дээд сургуулийн лекцийн хичээл ч гэсэн багш, оюутнууд санал бодлоо идэвхтэй солилцох хэлбэрээр явагдах боломжтой гэж үздэг байна. Түүний тул лекцийн хичээлээс өмнө оюутан уг хичээлийн агуулгатай танилцан өөрийн санаа бодлоо илэрхийлэх хэмжээнд үнэлэлт дүгнэлт хийх бэлтгэлтэй байхыг шаарддаг байна. Эл тохиолдолд багшийн үүрэг мэдээлэл өгөхдөө биш, оюутнуудын бие биеэсээ суралцахад туслах, шаардлагатай тохиолдолд тэдний үзэл бодлыг засаж залруулах, оюутнуудын үйл ажиллагааг дүгнэхэд чиглэх учиртай ажээ. Өөрөөр хэлбэл, багш ангид “бүхнийг мэдэгч, шийдэгч” субъект байхаа болино. Гэхдээ эл аргазүйн хандлага багшийн хувийн зан чанар, үзэж байгаа хичээлийн онцлогоос шалтгаалах нь

математик; практик урлагийн төрлүүд; шинжлэх ухааны практик хичээл ба програмчлал гэсэн хичээлийн долоон бүлгээс сонгох боломжтой ажээ. Түүнчлэн оюутнууд тооцоолон бодох аргазүй, тоон баримтуудыг боловсруулах хичээл үзэж сорилго өгөх үүрэгтэй байна.

ойлгомжтой. ЛБ нь багш бүрийн ангид заах арга барилыг хязгаарлах гэж оролддоггүй. Багш, сурагчдын харилцан идэвхтэй ажиллагаа байгалийн ухааны хичээл, жишээлбэл физикийн хичээлийн аргазүй түүхийн хичээл заах арга барил ялгаатай байх нь ойлгомжтой. Гэхдээ багшийн хувийн зан чанар, хичээл бүрийн онцлогоос үл шалтгаалсан тодорхой шаардлагыг ЛБ-ын явцад нийтэд тавьдаг байна. Үүнд:

- сургалт багш, сурагчдын хамтын үйлийн хүрээнд явагдах ёстой.
- оюутнуудын зүгээс асуулт тавих, аливаад шүүмжлэлтэй хандах хандлагыг дэмжих ёстой.
- багш мэдлэгийг дангаар эзэмшигч биш.
- сургалтын дийлэнх хэсэг ангид биш, сургалтын бус үед явагдах ёстой зэрэг болно.

6. ЛБ-ын тогтолцооны журам, дүрэм, зохион байгуулалт. Бид дээр ЛБ-ыг их, дээд сургуулийн бие даасан тогтолцоо болох үүднээс нь гол гол ойлголтыг нь өглөө. Тэгвэл одоо уг тогтолцооны бүтцийн онцлогийг нь *сургуулийн удирдлага – сургалтын төлөвлөгөө- заах аргазүй* гэсэн хэлхээнд доор авч үзнэ.

Бүтцийн анхдагч бүрэлдүүн хэсэг нь сургуулийн удирдлагын бүтэц юм. Энд юуны өмнө *сургалт явуулах цагалбар, оюутны мэдлэгийн үнэлгээний тогтолцоо, хичээлийн хуваарь* нь оюутанд олгох мэдлэг, чадварын өргөн хүрээ, гүн бат чанарыг хангах ЛБ-ын үндэс болдог байна. Хэдийгээр энэ нь улиг домог болсон үнэн хэдий ч түүнийг анхаарлын гадна орхих нь ЛБ-ыг хөгжүүлэхэд “чөдөр тушаа” болдгийг Унгар болон ОХУ-д олон улсын ЛБ-ын шинжээчээр ажилласан Ж. Беккерийн жишээг энд дурдахад сургамжтай байж болно. Тэр бээр коммунизмын үзэл суртал нурсан Унгарт 1990 оны эхэнд ЛБ олгохоор байгуулсан 500 орчим харьцангуй цөөн оюутантай Европын төв их сургууль бүр эхнээсээ 8 факультет нь тус тусын сургалтын 6 цагалбар буюу календарь, оюутны мэдлэгийг дүгнэх таван баллын тогтолцоотойгоор үйл ажиллагаагаа эхэлсэн нь факультет бүрийн хооронд нэгээс нөгөөд шилжих аргагүй “хана” босож нэг дамжааны оюутан нөгөө факультет, ангийн сургалтад оролцох бүхий л боломжийг үндсэнд нь хаасан байна. Түүнээс гадна, жишээлбэл улс төрийн ангийн оюутны нэг жилд сурах хугацаа 10 долоо хоног бол түүхийн ангийнх 16 долоо хоног байх зэрэг нь ЛБ-ын тогтолцоонд шилжих тухай ярих боломжгүй болгосон гэж Будапешт хотноо 2003 оны 6-р сард болсон “Нээлтэй нийгэм” эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлдээ Беккер дурджээ.

ЛБ олгох бүтцийн өөр нэг чухал бүрэлдүүн нь ангид хичээллэх оюутны цаг, нэг улиралд оюутны үзэх хичээлийн тоог зохистой тогтоох явдал юм. Оюутан баримжаатай, хичээл заах ардчилсан тогтолцоог эрхэмлэсэн ЛБ боловсрол нь *оюутан хүн ангид үзэх хичээлийнхээ агуулгатайгаа хичээлээсээ өмнө бие даан үзэж танилцахаас гадна оюутан бүр бичгийн ажил гүйцэтгэх учиртай тул* эл шаардлагыг ханган биелүүлэх боломжийг суралцагч хүнд олгох ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хуучин ЗХУ-ын их, дээд сургуульд оюутан ангид өдөр бүр 6-8 цаг өнгөрөөж, улиралд 14 хүртэл хичээл үздэг байсан уламжлал энд таарч зохицохгүй болно. Сургалтын тийм төлөвлөгөө нь оюутан хүн бие даан суралцах боломжгүй учраас зөвхөн багш түүнд мэдлэг олгох цорын ганц эх сурвалж нь болно гэж үздэг байна. Тиймээс АНУ-ын ЛБ олгодог их, дээд сургуульд сургалтын нэг улиралд 4-5 хичээл үздэг ажээ. Гэхдээ эндээс ангид үзэх хичээлийн ач холбогдлыг үгүйсгэх туйлшрал үүдэх ёсгүй. Харин ч эсрэгээр тийм тохиолдолд оюутны зүгээс хичээлийн

явцад олон асуудал гарах нөхцөл бүрдэж, тэрхүү асуудлыг тойрон хэлэлцүүлэг хийх боломж нээгддэг байна.

ЛБ-ын бүтцийн гутгаар чухал бүрэлдүүний нэг нь суралцах *оюутны тоо олон биш байх ёстой*. Гэхдээ тэрхүү тоо нь уг хичээлийн агуулга, онцлог, багшийн хувийн чанараас шалтгаалах учиртай. Өөрөөр хэлбэл, олон оюутантай ангид хүн бүр идэвхтэй оролцсон асуудлын хэлэлцүүлэг хийх боломжгүй нь ойлгомжтой.

Дээрх шаардлагын үүднээс хандвал сургалтын зардал өсөх нь ойлгомжтой. Тиймээс АНУ-ын төрийн томоохон сургуулиуд багшийн лекцийг нийтээрээ сонсоод дараа нь суралцагчдыг жижиг бүлгүүдэд хувааж дадлага, семинарын хичээлийг явуулах замаар асуудлыг шийдвэрлэдэг байна. Дадлага, семинарын хичээлийг магистрант, докторант оюутнууд гол төлөв удирдаж явуулдаг ажээ.

6. Заах аргагүй. Заах аргазүйн хамгийн эхний болзол нь өмнө бидний тэмдэглэснээр *суралцагч хүн үзэх хичээлийнхээ агуулгатай урьдчилан танилцсан байх* нөхцөл юм. Хэрэв эл нөхцөл бүрдээгүй тохиолдолд суралцагчтай багш хамтран ажиллах, асуудлыг хэлэлцэх боломж бүрдэхгүй. Уг нөхцөлийг бүрдүүлэхийн тул багш хичээл бүрийнхээ хөтөлбөрийг оюутнууддаа сэдэв бүрээр нь уншиж танилцах номзүйн хамт танилцуулж, тэдний гарт хүргэх учиртай. ЛБ-ын тогтолцоог хэрэгжүүлж эхлээд байгаа улс орнуудад энд багагүй бэрхшээл гарч байгааг ЛБ-ын олон улсын шинжээчид бараг бүгд тэмдэглэжээ. Эл нөхцөлийг бүрдүүлэх үүднээс багшийн оюутанд санал болгож байгаа бүх сурвалж сургуульд хангалттай байгаа эсэхийн тухай асуудал босож ирнэ. Түүний тул цахим номын сан, интернэт зэргийг ашиглах боломжид сургалтын эх сурвалжууд нь тулгуурласан байх учиртай ажээ.

Өмнөхөөс дутуугүй өөр нэг чухал асуудал бол *оюутны мэдлэгийг дүгнэх* явдал юм. Мэдлэг дүгнэх үйл нь юуны өмнө суралцагч хүнд нээлттэй, сургалтын олон талт үйл бүрийг багтаасан байна. Түүний тул хичээлийн хөтөлбөрт оюутны мэдвэл зохих мэдлэг, чадвар зэргийн зорилго, зорилт, түүний биелүүлэлтийг хэрхэн дүгнэх аргачлал зэрэг нь тодорхой туссан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ЛБ нь улирлын эцсийн ганц шалгалтын дүнгээр биш, оюутны суралцах хугацааны нийт дүн, явцын шалгалт, судалгааны ажил, хичээлд оролцсон байдал, илтгэл зэргүүдийг хамарсан үнэлгээ байх ёстой гэж үздэг байна.

7. ЛБ-д олон нийтийн зүгээс гарч байгаа шүүмжлэлд хариулсан олон улсын ЛБ-ын шинжээчдийн хариуг тоймлон хүргэе. Үүнд:

- ЛБ нь зөвхөн сонгодог урлагийн сургуулиудад зөвхөн хэрэгжих тогтолцоо биш. ЛБ-ын

тогтолцоо зөвхөн урлагийн салбараар хязгаарлагдахгүй болохыг түүнийг хэрэгжүүлсэн олон улсын цөөнгүй сургуулийн туршлага бэлхнээ харуулж байна. АНУ-ын олон сургуулиас судлаачид Мичиганы их сургуулийг онцлон тэмдэглэсэн нь цөөнгүй таарч

байна. (http://www.lsa.umich.edu/lsa/parents/liberal_arts)

- ЛБ-ын загвар нь ЕХУ-дад өдгөө баримталж байгаа дөрвөн жилийн баклавын сургалтын тогтолцоотой таарч тохирохгүй болохыг шинжээчид тэмдэглэжээ. Тэдний үзлээр өмнөх тогтолцоотой ЛБ-ын гол гол зарчим зөрчилдөнө.

- ЛБ-ын загвар нь өнөөгийн сургалтын уламжлалт тогтолцоог заавал шахан зайлуулж оронд нь ноёрхох зорилгогүй. Эсрэгээр эл тогтолцоо нь ОХУ болон хуучин соцорнуудын их, дээд сургуулиудад уламжлалт тогтолцоотой хослон амжилттай хэрэгжиж байгааг тэмдэглэжээ.
- Өнөөгийн ЛБ –д урлаг төдийгүй, хүмүүнлэгийн салбар бүхэлдээ татагдан орж байна. Түүгээр ч зогсохгүй судалгааны олон сав ухааны дундын шинжтэй салбарууд, жишээлбэл статистикийн салбар хүртэл эл чиглэлээр сургалт явуулж муугүй амжилтад хүрч байгаа ажээ.
- ЛБ-ыг ганц дан либерал үзэл сурталтай холбон тайлж тайлбарлах нь нийтлэг тааралддаг. Эл тохиолдолд ЛБ-ын тогтолцоо бүхий сургуулиудын оюутнууд ганц дан эл үзлийг биш орчин үеийн нийгэм-улс төрийн олон чиглэлтэй танилцах боломжтой байна.
- Нөгөөтээгүүр, ЛБ-ын тогтолцоог сонгосон сургууль бүр өөрийн төгсөгчдийг зөвхөн орчин үеийн зах зээлийн ажилгүйдлийн нөхцөлд таацуулан бэлддэг гэж ойлгож болохгүй. Олон улсын практикаас ажсан шинжээчид ЛБ-той төгсөгчдийг ажил олгогч хүмүүс, тэр дундаа хувийн бизнес, санхүүгийн салбарынхан ажилд илүү дуртай сонгон авдаг тухай олон баримт тэмдэглэсэн байна. Түүний учир нь төгсөгч хүн нэгэнт мэргэжлийн чиглэлийн сайн суурь дэвсгэртэй тул аливаа ажилд хөрвөн ажиллах дадлагатайгаас гадна аливаа асуудлын шийдэлд зөв байр сууринаас ханддаг гэж ажил олгогч хүмүүс үздэг байна.
- ЛБ-ын салбарт ажиллаж байгаа профессор багш нар нэгэн ёсны “цэцэрлэгийн хүмүүжүүлэгчид” болохгүй агаад эрдэм судлалынхаа ажлыг хийх өргөн боломжтой байдаг ажээ.

Одоо өмнө өгүүлснээ нэгтгэн дүгнэхийг оролдъё. Үүнд: 1) ЛБ-ын тогтолцоонд шилжихэд гарах цөөнгүй бэрхшээлийн нэг нь санхүүгийн нөөц бололцооны асуудал юм. Тэдгээрээс хамгийн том нь оюутнууд хичээлдээ бэлдэх цахим номын сан, шаардлагатай мэдээллийн эх сурвалжууд, зохион байгуулалттай холбоотой ажилтнуудын орон тоо нэлээн нэмэгдэх зэрэг нь өмнө байгаагүй ихээхэн зардал шаардана. 2) Боловсролын удирдах төрийн байгууллагын зүгээс шинэчлэлд хандах хандлага, сургалтын төлөвлөгөөний зөрүү, багш, оюутнуудын ачаалал, тэдгээрийн орон тооны асуудал зэрэг болно. 3) ЛБ-ын тогтолцоонд шилжих үеийн профессор багш нар, суралцагчид, тэдгээрийн эх, эцэг, нийт хүмүүсийн сэтгэлзүйн бэлтгэлийг хангах, тэдэнд уг тогтолцооны зохистой ойлголтыг төлөвшүүлэх явдал юм. Эцэст нь тэмдэглэхэд ЛБ нь боловсролын бүхий л асуудлыг шийдвэрлэхүйц “шидэт эмийн жор” биш ч гэсэн өнөөгийн манай гарагийн улс орнуудын даяарших чиг хандлага, эдийн засгийн хувьд улс орнууд бие биеийнхээ давуутай талыг ашиглан зах зээлд нэгдэх үйл явдал эрчимтэй өрнөж байгаа эрин үед иргэний нийгэм журамд шилжиж байгаа улс орнууд нийгмийн идэвхтэй иргэн хүнийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх тогтолцоо гэж үзэж байна.